

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах
дүрмийн 3 дугаар хавсралт

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2023 оны 06 сарын 06 -ны өдөр

Дугаар: 2023/006

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын Өмнөговь аймаг, Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд сумын нутаг дэвсгэрт баригдсан жилд 30 сая тонн хүртэл нүүрс тээвэрлэх хүчин чадал бүхий 1 дүгээр зэрэглэлийн төмөр замын барилга байгууламжид /багц 1, 2/ Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 125 дугаар шийдвэрээр байгуулагдсан 6 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн 2 хоногийн хугацаанд ажиллан Ачилтын тойрог замын ПК00+000 – ПК -8+395.5 /хос зам 16.79км/, Тавантолгой өртөөний ПК0+000 – ПК230+640 хүртлэх барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ: **Засгийн газрын 2019.07.24, 304 дүгээр тогтоол;**

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар: **зураг төслийн шифр дугааруудыг жагсаалтаар хавсаргав;**

2.3. Захиалагч: **“Тавантолгой төмөр зам” ХХК**, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: **000180806;**

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Юнион бюлдинг, Б блок, 11 давхар, холбоо барих утас: 77777727, цахим хаяг: info@ttz.mn;

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: **“Бодь интернэшнл” ХХК**, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: **2040443**, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар **064/2022, 063/2022, 062/2022, 061/2022, 033/2022, 22/A235/08;**

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, Парк Плэйс товер, 3-р давхар, холбоо барих утас: /11/315144, цахим хаяг: info@bodigroup.mn;

2.5. Барилгын ажлын туслан гүйцэтгэгч байгууллага: **жагсаалтаар хавсаргав;**

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: **зураг төсөл зохиогч байгууллагуудын жагсаалтыг хавсаргав;**

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: **“Тавантолгой төмөр зам” ХХК**, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: **000180806;**

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Юнион бюлдинг, Б блок, 11 давхар, холбоо барих утас: 77777727, цахим хаяг: info@ttz.mn;

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Хэвийн;**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

-Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

-Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

-Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Энэхүү жилд 30 сая.тонн хүртэл нүүрс тээвэрлэх хүчин чадал бүхий 1 дүгээр зэрэглэлийн төмөр замын зориулалттай барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Ашиглагч байгууллагад:

а). барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б). барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в). барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4. Комиссын акт ... хуудас, хуралдааны тэмдэглэл ... хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт ... хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох ... хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн жилд 30 сая.тонн хүртэл нүүрс тээвэрлэх хүчин чадал бүхий 1 дүгээр зэрэглэлийн төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Комиссын дарга:

Барилга, хот байгуулалтын яамны Барилга, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга



Д.Гантулга

Нарийн бичгийн дарга:

Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далан тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Төмөр замын тээврийн хэлтсийн дарга

A blue ink signature written over the stamp area.

Х.Итгэлт